



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 226.

Улаанбаатар хот

“Багануур АЗЗА” төрийн өмчит
хувьцаат компанийн дүрэмд өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 59 дүгээр зүйлийн 59.2, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 3.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчилсүгэй.

1.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 25,418,294.86 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Үүнд өөрчлөлт оруулах асуудлыг гагцхүү Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

2. Дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг “Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (А.Алтангадас)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

133001167

ТӨБЗГ тогтоол-/2021